

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 06/268

НШУС

2006

ДАЯАРЧЛАГДСАН МЭДЭЭЛЛИЙН НИЙГМИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: даяарчлагдсан мэдээллийн нийгэм, харилцаа, мэдээллийн технологийн шинэчлэлт, "даяарчлагдсан тосгон", Интернет.

Даяарчлагдсан мэдээллийн нийгмийн тухай үзэл баримтлалыг Даниел Белл, Элвин Тоффлер нар тавьж, аж үйлдвэржилтийн дараах нийгэм болохынх нь хувьд анх тодорхойлжээ. Гэхдээ өөр нэг эрдэмтэн Г.Иннис "мэдээллийн хэрэгсэл ба нийгмийн хэв маяг" хоорондын харилцан хамаарлыг тодорхой түүхэн эриний хөгжилтэй холбон үзэх анхны эмхлэгдсэн үзэл баримтлалыг боловсруулсан нь түүх, нийгмийн шинжлэх ухааны хандлагад цоо шинэ орон зайг бий болгосон юм.

Г.Иннис бичиг үсгийг мэдээллийн технологийн төвшинд үзэн, эрт цагийн эзэнт гүрэн нь зөвхөн цэргийн жанжин, баатруудын төдийгүй, хот бүхэнд хүрч байсан зарлиг тушаал, захидлын хүч хэмээн нотолжээ. Тийм ч учраас мэдээл-

лийн технологийн хөгжил нь улс төрийн төвлөрөл, эрх мэдлийн өргөжилт, орон зай цаг хугацааг эзэгнэх боломж чадавхийг нийгмийн элитэд бий болгож ирсэн хүмүүний түүх үргэлжилжээ. Тэгээд ч Даяарчлалын нэгдүгээр шат 1492 оноос эхэлсэн "Газар зүйн Ил нээлт"-ээс 1800 оныг хүртэлх дэлхийн худалдаа арилжааны их тэсрэлтээр төсөөлж, дараагийнхийг нь 1830-аас оноос буюу "Аж үйлдвэржилт"-ийн нягт балчир цаг гэгддэг уурын машины үеэс үндэстэн дамжсан корпорацууд төлөө шин тогтсон 1990-ээд он хүртэлх цагийг, харин нэн шинэ гуравдахь үеийг Интернет, тоон технологи, шилэн кабелийг хиймэл дагуулын эрин жинхэнэ утгаараа эхэлсэн 1991 оноос тоолдог. Даяарчлалын эхэн үед улс орнууд, дараа нь үйлдвэр компани, байгууллагууд тэгээд өдгөө хувь хүн "дэлхийн болсон" байж ишээтэй.

Энэ бүхнийг ч харилцааны томоохон онолч М.Маклюэны харилцаа мэдээллийн технологийн шинэчлэлт нь

нийгмийн өөрчлөлтөд хүргэх зайлшгүй хүчин зүйл болдог гэсэн үзэл санаа ч нотолдог. М.Маклюэн соёлын түүхэн хөгжлийн үе шатыг аман, бичгэн, дуу дүрст хэрэгслийн гэж ангилаад хүн төрөлхтөн бичгийн дүрмийн шугаман сэтгэлгээнээс шугаман бус цахилгаан сэтгэлэг үрүү орж байна хэмээн 1980-аад онд дүгнэжээ. Тиймээс ч түүний алдарт дүгнэлт болох "мэдээллийн хэрэгсэл өөрөө мэдээлэл болой"¹ гэсэн нотлол сэтгүүл зүй судлаачдыг байлдан дагуулсан юм. Өөрөөр хэлбэл, мэдээллийн шинэ хэрэгслийн хэлбэр бүр хувь хүн болоод нийгмийг бүхэлд нь дамжуулж буй утга мэдээллийн нөлөөний хамт өөрчлөн байгуулдаг гэсэн үг.

Энэхүү үзэл тайлбараар Монголын өнөөгийн нийгмийг тодорхойлбол, бидний ахуй байдал, ухамсар сэтгэлгээ нилээд зөрчилтэй дүр зураг бүхий байгаа юм. Тодруулбал хөдөө орон нутагт аман болоод бичгэн мэдээллийн хэрэгслийн ноёрхол хэвээр оршиж, долоо, арав хоног тутмын сонин ерөнхийдөө нийгмийн харилцааны гол суваг болж байхад, хот суурин газарт телевиз зонхилж байх жишээтэй. Гэхдээ хотын хүн амын мэдээллийн хэрэглээг авч үзвэл Интернет зэрэг цахим хэрэгслийн хэрэглэгчдийн хүрээ ч бий гэж байгаа.

Нөгөөтэйгүүр эдийн засаг, үйлдвэрлэлийн хүрээнд өндөр төвшний техник бүрэн дүүрэн нэвтэрч чадаагүй байгаа хирнээ шууд мэдээллийн эриний зарим нэг технологийн нэвчилт бодит зүйл болсон байгаа юм.

Телевизийн жишээгээр л гэхэд коммунист үзэл суртал, социалист реализмийн аргаар хийсэн кино, нэвтрүүлгийг сюрреалист, хүний эрх, даяарчлалын билэгдэл, домог бүхий өрнөдийн иргэншлийнхтэй хамт дараалуулан нэвтрүүлж, түүнийг нь үзэгчид, олон нийт ямар ч зөрчил, үгүйсгэл үгүй ойлгож бүр догдлон хүсч буй нь сонирхолтой гэмээр зүйл болоод байна. Өөрөөр хэлбэл, монголын нийгмийн мэдээллийн харилцаа

«

М.Маклюэн соёлын түүхэн хөгжлийн үе шатыг аман, бичгэн, дуу дүрст хэрэгслийн гэж ангилаад хүн төрөлхтөн бичгийн дүрмийн шугаман сэтгэлгээнээс шугаман бус цахилгаан сэтгэлэг үрүү орж байна хэмээн 1980-аад онд дүгнэжээ.

»

дээллийн харилцаа яг ямар дүр төрх, байдалтай байна вэ гэдэгт хариу олдохгүй байна гэсэн үг. Хамгийн энгийн жишээ гэхэд л гар утаснаасаа зураг дуу татаж суугаа нэгэн энгийн зууханд боловсруулаагүй нүүрс түлж утаанд нь нүдээ хорсгож суугааг бас кимчи идэж, хятал хоолны газар шинэ жилээ тэмдэглэж байгаа хирнээ сум нутгаа бахдаж, эх орон, тусгаар тогтнолоо хамгаалах тухай үзэл санааг бахдаж буйг юу гэж тодорхойлох вэ гэдэг байна.

Асуудлыг үргэлжлүүлэн үзвэл бүр ч сонирхолтой болно. М.Маклюэн

"дачарчлагдсан тосгон" хэмээх ойлголтоор өндөр хурдтай электрон хэрэгслээр нэгэн нийтлэг болон холбогдсон дэлхийн нийгмийг тодорхойлж, харин Г.Иннис мэдээллийн хэрэгслийг "хүний үргэлжлэл" хэмээн тунхаглан, улмаар энэ нь нийгмийн нүд хараа, сонсголын орон зай, цаг хугацааг тэлэн өргөжүүлсэн болохыг тайлбарлан нотолсон юм. Үнэхээр ч электрон хэрэгсэл жирийн хүнд хаана ч хормын төдий хугацаанд "хүрч, байх" шинэ уудам орон зайг нээж өгсөн билээ. Харин бид дэлхийн хүн мөн үү, мэдээллийн шинэ технологи бидний орон зай, цаг хугацааг өргөжүүлсэн үү гэвэл аль алинд нь "хагас, хагас" гэсэн хариулт дүйж байх шиг. Нэг талаас бид Олимпийн тоглолтоос дэлхийн эдийн засгийн хямрал хүртэлх бүхий л мэдээллийг цаг тухайд нь шуурхай хүлээн авч байгаа маань үнэн боловч, нөгөө талаас тэр бүхнээс бид үзэл санаа, үйл байдлын хувьд ч "тусгаарлагдмал, үл нэвтрэлцэх" төвшинд буй маань бодит зүйл билээ.

Өөр нэгэн зүйл нь Өрнөдийн судлаачдын хувьд ч орчин үеийн нийгмийн онцлог шинж төрхийг мэдээллийн хэмээн тодотгож байгаа ч чухам юу нь тийм хувьсган шинэчлэгч болох тухай асуудалд нэгдсэн үнэлэлт дүгнэлт өгч чадахгүй, маргаантай хэвээр байгаа гэнэ. Гэхдээ үзэл бодлын янз бүрийн хандлага, байр суурь эцсийн эцэст мэдээллийн үр нөлөө чухал болсон гэдгийг хүлээн зөвшөөрөөд буй юм. Магадгүй энд өмнө өгүүлсэн Монголын

нийгмийн зөрчилт дүр байдлын хариу, шалтгаан оршин байж болох юм. Мэдээллийн нийгэм хэмээх үг хэллэг ч нэгэнтээ хүн зоны дунд түгээмэл ойлголт зүйл болж, улмаар социологи, философи, эдийн засаг, харилцааны шинжлэх ухаанд мэдээллийн нийгмийн тухай үзэл баримтлал ямар нэг нэр, ойлголтоор илэрхийлэгдэн олон ном бүтээлд тусгагдан бие даасан асуудал, судлагдахуун болжээ.

Ерөнхийдөө мэдээллийн нийгмийн үзэл санаа нь мэдээллийн болоод техник, технологийн хэрэгсэл, түүний дамжуулах, хадгалах, боловсруулах үйл явцыг нийгмийн харилцамжийн олон хүчин зүйлтэй холбон нэгтгэн томъёолж, асуудлын ирээдүй, хэтийн төлөвийн зэрэг ба сөрөг үр дагавар нөхцөл байдлыг, авч үзсэн янз бүрийн чиг хандлага, байр суурийн цогц номлол гэж болно. Нөгөөтэйгүүр мэдээж мэдээллийн нийгэм гэдэг бол мэдээлэл-бизнес үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хамгийн үнэт баялаг төдийгүй, гол бүтээгдэхүүн нь байж, нийгэм эдийн засгийн үндсэн чиг хандлага, шинж төрх нь болдог тийм нийгэм гэдэг нь ойлгомжтой. Тэгээд ч ажиллах хүчний ихэнх хувийг мэдээллийн ажилтнууд эзэлж байдаг билээ.

Энэхүү мэдээллийн ажиллагсад гэдэгт хамгийн ерөнхий утгаар нь авч үзвэл мэдээллийн үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт зэрэгт оролцдог болон мэдээллийн технологийн салбарынхан ба бусад холбогдох мэргэжилтнүүдийг

багтаадаг болно. Энэ утгаараа ч өндөр хөгжилтэй улс орны мэдээллийн эдийн засгийн салбарт ажиллагсдын тоо эрс өсч байгаа билээ. Бүр 1980-аад оны дунд үе гэхэд АНУ-ын нийт ажиллах хүчний 50 гаруй хувийг мэдээллийн салбарынхан эзлэх болжээ. Харин манайд энэхүү бизнес эхлэл төдий, онгоцны тийз зарах, санхүүгийн зарим нэг үйлчилгээгээр л хязгаарлагдаж байх жишээтэй. Картын хүрээ, хэрэглээ ч явцуухан хүрээнд оршиж буй төдийгүй олон нийтийн дунд ч үл итгэх хандлага хэвээр байсаар...Нэг үгээр хэлбэл, мэдээллийн технологийн хэрэглээ, бодит оролцоо нөлөө монголын санхүү, бизнесийн ертөнцөд бараг үгүй гэсэн үг. Гэтэл чухам энэхүү үзүүлэлт, төвшин л мэдээллийн нийгмийн гол үндсэн шалгуур гэдгийг өмнө тэмдэглэсэн. Энэ ч утгаараа ВЕБ хүрээлэл нэмэгдэж, NETSCAPE олон нийтийнх болж, эгэл жирийн хүн ямар ч байгууллага болоод мэргэжилтний дэмжлэг, оролцоо үгүйгээр ИНТЕРНЕТ-эд мэдээллээ байршуулж, шинэчилж, сэргээж байгаа юм. Бас 30 ажилтантай нэгэн компани SONY, HYATT, ESTEE LAUDER-ийн реклам сурталчилгааг salesforce.com мэдээллийн баазыг ашиглан хийн, жилийн сая долларын ашиг олж, алдарт HEWLETT PACKARD зул сарын баярын өдрүүдэд 400 мянган компьютер борлуулж, оффшорингийн (хямд зардал бүхий газар үйлдвэрлэлээ байршуулж, бүтээгдэхүүнээ эргүүлэн импортлох) үр дүнд Америкийн үйлдвэрлэгчид зөвхөн

Хятадаас л гэхэд 2005 оны байдлаар 600 тэрбумын хэмнэлт хийсэн гэж байгаа.

Тэгээд ч М.Маклюэны үзэл баримтлалаар мэдээллийн нийгэм нь агуулгын бус, харин түүнийг үйлдвэрлэгч хэрэгслийн хувьсагч хүч нөлөөнд оршиж байгаа юм. Чухамдаа үүний дараа л ашигт хэрэглээ, эрх мэдлийн харьцаа, нийгмийн үнэлэмж, давхарга бүлэглэл, ажил хөдөлмөрийн онцлог зэрэг нарийн түвэгтэй асуудлыг тодорхойлох ёстой гэжээ. Харилцааны технологийн шинэчлэлт болон шинэ хэрэгсэл нь үнэхээр олон нийтэд мэдээллийг хүргэх нэг талын урсгал, эсвэл төвөөс дамжигчид үрүүгээ ханддаг чиглэл бүхий тогтолцоонд өөрчлөлт оруулаад байна. Үнэхээр одоогийн байдлаар Google-ээр л гэхэд өдөрт хүмүүс 1 тэрбум гаруй хайлт хийж, Yahoo 300 гаруй сая хэрэглэгч, 4 сая орчим идэвхтэй группыг нэгтгээд байгаа нь сэтгүүл зүйн уламжлалт "эх сурвалж-мэдээлэгч-нийгэм" гэсэн загварыг бүрмөсөн өөрчилж буйн жишээ билээ. Гэхдээ хувьсал өөрчлөлтийн жинхэнэ утга учир хэрэгсэл ба нийгэм хоорондын харилцаа холбооны шинж чанарт тодруулбал "хуучин" хэрэгсэл урьдын адил ноёрхож чадахгүй, харин шинэ (сансрын телевиз, интернет) оршин буй тогтолцоонд хараахан байр сууриа олоогүй үед бодитой илт байдаг юм. Энэхүү үзэгдлийг ч "неотехнологийн хүчин шалтгааншилт" хэмээн томъёолжээ.

Хэдийгээр суурь үндсэн асуудал зах зээлийн нөлөө байр суурийн төлөөх өрсөлдөөн, хэрэгслийн нэгдэлшилт мөн боловч мэдээллийн нийгмийн өөр бусад чухал зүйлд хэрэгсэл ба нийгэм хоорондын харилцаамж холбоо тэр дундаа мэдээлэл хүртэгчийн мэдээлэгчээс хараат бус, бие даасан байдал өсөн нэмэгдсэн, мэдээллийн хэрэгслийн үндсэн үүрэг өөрчлөгдсөн (илүү их мэдээлэл), хэрэгсэл

хоорондын болоод боловсрол, ажлын газар, гэр бүл, хувь хүмүүс хоорондын гээд бусад харилцааны хүрээний зааг ялгаа багассан гээд олон талаар хувьсан өөрчлөгдсөнийг хэлэх хэрэгтэй.

Социологийн профессор Д.Беллийн удирдаж нэрт ирээдүй судлаач Г.Каны

оролцсон судалгааны багийн тайланд (хамтран зохиогчоор Э.Винер) "мэдрэмж сэрлийн соёл"-ын даяаршсан түгэлтийн хэтийн төлөвийг үзэл-оюун ухааны агуулгын бус, харин бие хүний гадаад хүрээ, орчиндоо хандах зөн-мэдрэмжийн харьцааных болсон хэмээн томъёолжээ. Тэд М.Маклюэний "даяаршсан тосгон"-ыг "даяаршсан том хот" болгон өөрсдийн үзэл тайлбараа тодотгож, тосгон бол төрөл төрөгсөд, хөрш, нийгмийн холбооны шууд барилдлага болоод

оюун санаа-ёс суртахууны нэгдмэл төлөв байдлынх учир том хотын бие хүний бүрэн эрх чөлөөт материаллаг эд баялгын холбоо бүхий ойлголтоор солих ёстой гэнэ. "Зөн-мэдрэмж"-ийн соёлын даяаршилд ОНМХ-ийн төдийгүй ирээдүйн "дэлхийн соёл нийгэм болон эдийн засгийн гол хөдөлгөгч хүч"² болох аж үйлдвэржилтийн дараах үеийн үндэстэн дамжсан корпорациудын нөлөө ч байгаа юм.

«

Урьд өмнө олон нийт сонин хэвлэлийн оролцоо нөлөөгөөр өөрсдийн үзэл суртлыг нотлон тайлбарласан улс төрийн нам, эвлэлийг тойрон нэгддэг байсан бол, "техно хаанчлал"-ын эринд энэхүү үүрэг нь дуу дүрст, цахим мэдээллийн хэрэгсэлд шилжснээ, үндэстний дүр сэтгэхүйг үндэснийх нь хэлээр дамжуулдаг сонин хэвлэлийн нөлөө хязгаарлагдмал болжээ.

»

үндэснийх нь хэлээр дамжуулдаг сонин хэвлэлийн нөлөө хязгаарлагдмал болжээ. Дэлгэц дүрсний харилцаа нь уламжлалыг эвдэж, хэлийг дүр дүрслэлээр, үндэстний ухамсрыг даяарчлалын төсөөллөөр сольжээ. Хүмүүс ч янз бүрийн улс орон, үндэстний амьдрал, үйл явдлыг ертөнцийн үзэл даяарчлагдсан үнэлэмжээр, илүү дэлхий дахины байр суурь, эрх ашиг, сонирхлоор хүлээн авах болов.

Тэгээд ч харилцаа-телевизжилтийн нэгдэл нь хүн төрөлхтний даяаршсан "мэдрэлийн тогтолцоо"-г төлөвшүүлж, дэлхий ертөнцийн иргэншлийг мэдрэмж сэрэхүйн төсөөллөөр нэгтгээд зогсохгүй бодит байдлын оюунлиг ойлголт гэхээсээ өөрчлөгдөн хувьсагч тодорхойгүй сэтгэгдлээр эмхэлж байгаа билээ. Түүнчлэн "техно хаанчлалын эрин" нь байрлал, нутаг дэвсгэрийн бус, харин орон зай цаг хугацааны эзэгнэлийг тээж буй нь дуу дүрст мэдээллийн шинэ хэрэгслийн дэлхийчлэлийн давалгаа бүхнийг нэгтгэн эзэмдэхийн хамт нэгэн ижил загварын хувцас, зан үйл, ахуйн болоод чөлөөт цагийн орчин, амьдралын хэв маяг түгэн тархаж, энэ бүхнийг нэгтгэгч олон нийтийн соёл, хэрэглээ, материаллаг баялаг, эд зүйлийн даяаршлын нөлөө идэвхижиж байгаагаар нотлогдох юм.

Орчин үеийн хүн нэгтгэгдэн дэглэгдсэн, дэлгэрэнгүй өөр хоорондоо холбоотой утга агуулга үзэл санааг бус, харин товч, хэсэгчилсэн, хялбар мэдээлэл болох реклам, мэдэгдэл, хэсэг бусаг баримт, мэдээ зэрэг зүйрлэн хэлбэл үйл явдал асуудлын "мөсөн уулын оройн хэлтэрхийг" л сонирхох болжээ. Өөрөөр хэлбэл, шинэ мэдээллийн урсгалыг хуучин үзэл баримтлал, ойлголтоор тодорхойлон үзэх боломжгүй учир холбоогүй, ойлгомжгүй, эмх цэгцгүй мэт төсөөлөл төрөөд байгаа юм. Гурав дахь эриний хүмүүс мэдээллийн "цахилгаан дайн"-ы хагас минутын дүрст мэдээ, дөрөвний нэг минутын реклам,

дууны клип, гарчиг, шугам хүрэх, график зураг, мэдээний хайрцаг гээд олон "бөмбөг"-т өртөж буй билээ. Ирээдүйн уншигчид хямд ном, "үздэг" сэтгүүлээр унших эрэлт хэрэгцээгээ хангаж, мэдээллийг нэгмөсөн залгих эрмэлзэлтэй болох гэнэ. Гэхдээ бас тэрхүү мэдээллийн "хэлтэрхийнүүд"-ээ ямар нэгэн цогц нэгдмэл зүйл болгон шинэ үзэл баримтлал, төсөөлөл, харьцууллын хүрээнд нэгтгэн хэсэг бусаг баримт мэдээгээ ойлгохыг эрмэлздэг гэж байгаа. Энэ нь аж үйлдвэржилтийн эриний стандарт бүтэц, зэрэглэл, ойлголтыг шинэ загвараар өөрчлөхийг эрмэлзэхийн оронд олон нийт ердөө мэдээллийн шинэ хэрэгслийн "эрчимт" "тасархай" баримт мэдээллийг ойлгох өөрсдийн үзэл санааны "бүс"-ийг бий болгож байгаа хэмээсэн хэрэг.

Энгийнээр хэлбэл хүмүүс хоорондын мэдээллийн солилцоонд нийцүүлэх, эрчимжүүлэх тийм боломж нөхцлийг бий болгоход мэдээллийн стандарт, илэрхийллийн төлөвшил чиглэж байна гэсэн үг. Үнэндээ олон нийтийн мэдээллийн соёл нь жинхэнэ утгаараа бол дамжуулан түгээх болоод эдүүгээчлэгдсэн хүний мэдэллийг хэрэглэх зохилт байдаг хэвшилд зохируулсан хэв маягийн нийтлэг болой.

Нэгтгэн үзэхэд Маклюэний "даяаршсан тосгон", Канын "даяаршсан их хот", Тоффлерийн "электрон сууц" зэргийн тухай үзэл санаа нь ирээдүйн

иргэншлийн үндсэн цөм, байгуулалт тогтолцооны эх сурвалж болж байна.

Мэдээллийн нийгмийн шинэ эрхэмлэл, билэгдэл домгийг Ф.Фейес, Ж.Швоч нарын тэмдэглэсэнчлэн түүхэн эрин бүр өөрийн мөрөөдөл тэмүүлэлтэй байдаг гэдэг утгаар үзвэл сансрын хиймэл дагуул, кабелийн телевиз компьютер гэсэн "ариун гурав" болно. Тэгээд ч Дундад зууныг Христийн шашны, XIX зууныг аж үйлдвэржилтийн, XX зууныг хэрэглээний соёлын, харин XXI зууныг мэдээллийн хэмээн онцлох болов. Энэ ч үүднээс сансрын технологи нь бүхнийг ивгээгч "Эцэг", телевиз нь түгээн дамжуулагч, "сайн мэдээг" хүргэгч "Хүү", харин компьютер нь бидний амьдралын цаг үед оршигч "Ариун Сүнс" юм гэж христийн шашны домог билэгдлийн "ариун гурав"-аар харьцуулан тодорхойлсон хэрэг.

Өнөөдөр бидний шинэ хэмээн үзэж байгаа хэрэгслүүд бүр 1970 оноос эхлэн мэргэжилтнүүдийн дунд яригдсан аж. Шинэ хэрэгслүүдийн уламжлалт хэлбэрийнхээс ялгагдах онцлог шинж нь нэгдүгээрт, төвлөрлийн бус орчин буюу мэдээллийн илэрхийлэл, сонголтын асуудалд улам бүр нийлүүлэгч, хангагчийн нөлөө, оролцоо үгүй болж байгаа явдал, хоёрдугаарт, нэвтрүүлэх чадавхи боломжийн өндөр төвшинд хүрсэн сансрын хиймэл дагуулын техник, технологийн цаг хугацаа, орон зайн хязгаарлалтаас үл хамааран дамжуулах чадвар, гуравдугаарт, эргэх харилцан

холбоот байдал хэмээх хэрэглэгчийн хүссэн мэдээллээ сонгох, түүнийг бусдад шууд дамжуулах, эргэх харилцаанд орох боломжид тулгуурласан хэрэглээ эдгээр болно. Тиймээс ч Yahoo-г үндэслэгч Жерри Янг "Хүмүүс өөрийгөө эмчлэх, зугаацуулах бас хоол хүнс машин, байр бүтээгдэхүүн авах мэт бүхий л үйлдлийг хийхээсээ өмнө мэдээлэл хайх болсон. Үүний үр дүнд тэд илүү ухаантай сонголтоо хийх ёстой болсон" гэсэн нь шинэ хэрэгслийн онцлог, ялгааны мөн чанарыг тэмдэглэсэн хэрэг.

Түүхийн талаас үзвэл XX зууны төгсгөл нь мэдээллийн технологийн хөгжлийн эрс хурдацын үр дүнд харилцааны цоо шинэ тогтолцооны гэрч болсноороо онцлог юм. Үүнийг бусад хэрэгсэлтэй харьцуулан үзэхэд ч сонирхолтой. Сонин мэдээллийн зонхилогч, гол хэрэгсэл болохын тулд анхны хэвлэлийн суурь машиныг бүтээснээс хойш гурван зууныг үдэж байхад, радио долгионы нээлтийг Герц хийгээд тогтмол нэвтрүүлэгтэй болохын тулд радио гучин гурван жил (1888 оноос 1921 он хүртэл) болж байжээ. Харин 1946 онд компьютер электрон хэлбэрээр (лампын технологи) бүтээгдэж, орчин үеийн хүчирхэг, овор багатай цахим хэрэгслийн үндэс бичил чип 1971 онд төрөөд 4 жилийн дараа олон нийтэд худалдаалагдсан гэнэ. Тэр үед Apple Xerox Commodore компани компьютер үйлдвэрлэж, 1981 оноос IBM зах зээлд PC санал болгож гурван жилийн дараа Apple компани анхны Macintosh-ийг

хулгана, Microsoft-ийн үйлдлийн системийн хамт нийлүүлжээ. 1991 онд ЗХУ-ын задрал, коммунизмын сүйрэл уналтын хамт Интернетийг арилжааны зорилгоор ашиглахыг зөвшөөрснөөр мэдээллийн утгаар XXI зуун эхэлсэн гэдэг.

Мэдээллийн шинэ хэрэгсэл бүр хүмүүсийг шинээр бас бат ноттой нэгтгэн холбох тийм боломжийг агуулж байж сая шинэ нийтлэгшлийн орчныг бүрдүүлэн төлөвшүүлснээр соёл сэтгэхүйн сөрөх ялгааг даван туулж, орон зай цаг хугацаагаа эзэгнэдэг болохыг түүхийн аль ч цаг үеэс харж, ойлгож болно. Мэдээллийн үйлдвэрлэлийн тогтолцоо аливаа шинэ бүхнийг нэвтрүүлэхдээ түүний боломж чадавхийг дээд зэргээр ашиглахын зэрэгцээ хэрэгсэл нь ардчилал, соёлын нийтлэгшил, хүлцэн тэвчихүй, эрчимт болон нийгмийн тогтвортой өөрчлөлтийн хүчин зүйл, түшиг тулгуур байх төгс орчин ахуй хэвшлийг бий болгохыг эрмэлзсээр иржээ. Гэхдээ мэдээж шинэ хэрэгсэл нь нийгмийн оршин буй дэг журам, мэдээллийн харилцааны төлөвшиж тогтсон орчныг өөрчлөн эмх замбараагүй, зөрчилт байдлыг бий болгох, улмаар олон нийтийн дунд үгүйсгэсэн сөрөг уур амьсгалыг дагуулах боломжтойг үгүйсгэж болохгүй. Түүнчлэн радио фашизмыг, телевиз хүчирхийлэл, садар самууныг, интернет терроризмыг сурталчлагч гол үндсэн хэрэгсэл байсан хийгээд байгааг ч хэлэх хэрэгтэй. Тиймээс ч шинэ хэрэгслийн асуудлыг эерэг хийгээд сөрөг аль аль талаас нь

үнэлж дүгнэж зохицуулах, нийгмийн эрхэмнэл, үнэлэмж, хэм хэмжээнд нийцүүлэн төлөвшүүлэх ёстой.

Нөгөө талаар мэдээллийн шинэ хэрэгсэл нь хувь хүний сэтгэл зүй, үнэлэмж тэр бүү хэл амьдралын хэв маягт өөрчлөлт авчирч, илүү сонирхолтой, үр ашигтай, өөр орон зайг тохинуулдаг гэдэг. Тэгээд ч хүмүүсийн соёл сэтгэхүйн хүрээг тэлж, олон нийтийг идэвхитэй, өөдрөг хүч, ертөнц болгодог. Харин энэхүү дүгнэлтийг үгүйсгэгчид шинэ мэдээллийн технологи нь “дундаж” хүний дүр сэтгэхүйг улам бүр бататгаж, түүний эрмэлзэл хүслийг явцууруулж, олон нийтийн нэг байх ухамсар хандлагыг төлөвшүүлж байна хэмээн шүүмжилдэг. Үүний эсрэг талынхан асуудлыг бие хүний, “өөрийгөө мэдэх” эрх, хариуцлагатай холбон мэдээллийн хэрэгслийг ардчилсан засаглалын хэв маяг, тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх түшиг тулгуур, хүчин зүйл хэмээн үздэг.

Түүнчлэн шинэ мэдээллийн технологийг хүмүүс янз бүрийн соёл заншлыг эрхэмлэж, өөр хоорондоо хүлээцтэй хандан нэгэн ойлголцол зөвшилцөлд хүрэх нэгэн нөхцөл, арга зам болохыг, тийм нийгмийн тогтолцоо байж болохыг номлодог. Харин энэхүү баримтлалыг үгүйсгэгчид шинэ технологи нь харин ч соёлын хэв шинж хоорондын зөрчлийг хурцатган, өөр соёлын нөлөөнд автан уусах аюулыг бодитой болгож байна гэдэг. Тэр бүү хэл тэдний бодлоор мэдээллийн шинэ

хэрэгслийн нэвчилт ирээдүйн иргэншил хоорондын дайнд хүргэх хүчин зүйл ажээ.

Шинэ мэдээллийн технологитой холбоотой хамгийн гол томоохон асуудал нь түүний олон нийтийн харилцааны тогтолцоонд хэрхэн орших, яаж холбогдохыг урьдчилан тодорхойлох явдал юм. Мэдээж зөвхөн шинэ технологи гэдгээр асуудлыг томъёолж болохгүй. Зарим шинэ

технологии олон нийтийн харилцааны тогтолцоонд нэн таатай холбогдох, байр сууриа олохоор шинж чанартай байдаг ч туршилтын үедээ алга болсон ч түүх бий.

Телевизийн дараа хэд хэдэн шинэ мэдээллийн хэрэгсэл гарсан боловч тэр бүхэн амжилт олоогүй ба зарим нэг нь болох

кабелийн, сансрын телевиз л олон нийтийн харилцааны ертөнцөд үлдэж чадсан юм. Харин теле бичвэр, видео бичвэр, цахилгаан бичгийн машин зэрэг нь ид олон нийтийн сонирхлыг татаж байх үедээ л алга болсон юм. Тэгэхлээр ирээдүйн шинэ хэрэгсэл ч улс төр, нийгэм, сэтгэл зүйн гээд олон хүчин зүйлээр шүүгдэж байж сая оршин үлдэх нь тодорхой болох бөгөөд маргааш чухам ямар хүчин нөхцөл тэр бүхнийг тодорхойлохыг хэн ч урьдчилан

тааварлаж чадахгүй учир нарийн гүнзгий дүн шинжилгээ л хамгийн бодитойгоор технологийн хөгжил хандлагын чиг зүгийг заах нь ойлгомжтой юм.

Шинэ хэрэгсэл, технологи нь ардчилсан ч бай, дарангуйлагч ч бай аль ч улс төрийн тогтолцоонд үйлчилж, хувь хүний амьдрал, нууцад нэвтрэх, эсхүл сонирхсон хэн бүхэнд "бусдад хэлэмгүй баримт, үнэнийг" мэдэхэд ердөө л нэг товчлуур дарах тийм нөхцөл боломжийг бүрдүүлснийг хэлэх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр мэдээллийн шинэ орчин нь нийгмийн эрх мэдэл бүхий хэсэгт бодит байдлыг тусгах бус, харин төөрөгдүүлэх орон зайг нээж өгсөн билээ.

Мэдээллийн шинэ хэрэгсэл, технологи бүтээгчдийн өмнө хэрэглэгчдийн эрэлт

хэрэгцээ сонирхол, сэтгэл ханамжаа гадна уламжлалт хэв маяг байдлыг төгөлдөржүүлэн сайжруулах зорилго оршдог ажгуу. Тиймээс шинэ хэрэгсэл бүр байр сууриа олж, амжилтад хүрэхийн тулд өмнөхөөсөө илүү агуулга хэрэглээ, үнэ, хүртээмж, нөлөөллийн зохист орчин, тогтолцоог бий болгоучиртай ба энэ утгаараа ирээдүйн мэдээллийн технологи нь телевиз компьютер, радио, кино, сонин сэтгүүлээс давж гарах хэрэгтэй болж байна.

«

Шинэ хэрэгсэл, технологи нь ардчилсан ч бай, дарангуйлагч ч бай аль ч улс төрийн тогтолцоонд үйлчилж, хувь хүний амьдрал, нууцад нэвтрэх, эсхүл сонирхсон хэн бүхэнд "бусдад хэлэмгүй баримт, үнэнийг" мэдэхэд ердөө л нэг товчлуур дарах тийм нөхцөл боломжийг бүрдүүлснийг хэлэх хэрэгтэй.

»

Шинэ хэрэгслийн талаарх судлаач мэргэжилтнүүдийн санал нэгэн зүйл дээр тогтоод байгаа нь эргэх холбоот харилцааны эрин эхэлжээ гэсэн дүгнэлт болой. Өөрөөр хэлбэл олон нийтийн харилцааны сонгодог үзэл онолд байдаг нэг талын, шугаман урсгалт хэв маяг, "нэг цэгт тэмүүлэх" болон өөрчлөгдөж байна гэсэн үг. Тийм жишээ ч байна. Түүнийг компьютерийн харилцаа гэдэг.

Манай нэгэн нэртэй орчуулагчийн санал болгосноор тооцуур хэмээн орчуулах ёстой гэдэг компьютер нь судлагдахуун болж, эрдэм шинжилгээний эргэлтэд орохын хувьд саяхны, болоогүй түүхий хэвээрээ л байгаа юм. Тэгээд ч компьютерийн технологи, программ хангамж, үйлдлийн орчин өндөр хурдацтайгаар эрчтэй хөгжиж ирснээр 1980-аад онд дөнгөж нийгмийн хандлага баримтлалд цухас дурдагдаж байсан зүйл 20 жилийн дараа л гэхэд харилцааны бие даасан, бодит орчин тогтолцоо болсон байх жишээтэй. Гэхдээ компьютерийн харилцаа нь телевиз шиг цоо шинэ үзэгдэл болсон шинж төрх, нөлөө байр суурь гэхээр онцлог үгүй, тийм харагдахуйц хэтийн төлөв ч үгүй байгаа гэнэ. Хэдийгээр компьютерийн тоо хэмжээ, хэрэглэгчид, хэрэглээний орчин өсөн нэмэгдсээр буйг ч дэлхий нийтийн, хүн төрөлхтний түгээмэл мэдээлэл, харилцааны хэрэгсэл болоогүй л байна. Дэлхий ертөнцийн дийлэнхи хувь нь өөр харилцааны (сонин, радио, телевиз) эринд амьдарсаар л байна.

Интернетийн түгэлт, төлөвшил эрчтэй өрнөж, түүний үр дагавар болох сүлжээнүүд даяаршлын хүрээ мөн чанарыг бодит зүйл болгон, тэрхүү утгаараа сүүлийн хорин жилийн дотор нийгмийн харилцааны нэгэн цогц тогтолцоог эмхэлж, шинэ хэлбэрийн хэрэглээ, соёл, ахуй орчинг бүрдүүлээд байгаа билээ. Гэхдээ мэдээллийн томоохон сүлжээ нь ердөө л технологийн нээлт төдий зүйл болж, хэдийгээр өргөн хүртээмж, засгийн газар, ашиг орлогын явцуу сонирхол, эрх ашгаас хараат бус харилцааны орчны бодит шалтгаан, хөдөлгүүр нь болж чадсан ч нийгмийн тэгш бус байдал, анги ялгааг улам бүр тодотгосон харамсалтай үр дагаварын "эзэн" болсон юм.

Өөр нэгэн Интернетийн орчин, харилцааны асуудал нь түүнийг бүрдүүлэгч хүчин зүйлийг ялган, тодруулбал, тоног төхөөрөмжийн болон программ хангамж талаас авч үздэг бусад хэрэгсэлд үгүй хандлага, үзэл баримтлал зонхилж байгаад юм. Түүнчлэн Интернетийн бүхий л сэдэв агуулга, хэлбэрийн мэдээллийг дамжуулдаг боломж, орон зай нь террорист, гэмт хэргийн байгууллага, хувь хүн ч өөрийн зорилгодоо ашиглах үүд хаалгыг нээн өгч, ямарваа нэгэн хяналт тавихад бэрхшээлтэй байдгийг ч олон шүүмжлэгчид онцолдог.

Интернет хэрэглэгчдийн тоо ч эргэлзээтэй, сүлжээнд холбогдох төдийгөөр хэрэглээний төвшин үзүүлэлтийг тодорхойлох нь учир дутагдалтай ба янз

бүрийн хүчин зүйл, зорилго, шалтгааны оролцоотойгоор дүгнэх боломжтой, харилцагсдын идэвхи, хүрээ өөр өөр байгаа нь асуудлыг улам нарийн түвэгтэй болгож байгаа билээ. Монголын нийгмийн хувьд 2003 оны байдлаар нийт хүн амын 7,3 хувь буюу 170 гаруй мянган хүн³ Интернетийг хэрэглэдэг гэсэн дүн гарсан ч хэрэглээний 90 шахам хувийг захидал бичих, e-mail шалгах, чаатлах, мэдээ унших эзэлж байгаа бөгөөд бараг бүх хэрэглэгчид нь нийслэлд амьдарч сурч буй оюутан залуус, албан хаагчид, ажил хэрэгч хүрээнийхэн болой. Харин дэлхий дахины хувьд өндөр хөгжилтэй, эдийн засаг санхүүгийн тэргүүлэгч улс орны хүн зон илүү идэвхитэй, өндөр төвшинд, бодит хэрэглээ болгон нийгмийн амьдрал, харилцааны салшгүй хэсэг болгон төлөвшүүлсэн байхад ядуу буурай, хоцрогдсон улс үндэстний хувьд "мөрөөдөл" хэвээр байна.

Тэгэхлээр компьютерийн харилцааны үр нөлөөг үнэлж цэгнэхэд өөр технологитой нийгмийн орчин хүрээний харьцуулал хийх хэрэгтэй болно. Телефон утасны хувьд л гэхэд хүмүүсийн нийгмийн харилцаамжийн тэлэлт, дадал хэвшлийн эрэлт хэрэгцээгээр өргөжин хөгжиж байжээ. Өөрөөр хэлбэл телефон утас нь амьдралын салшгүй нэгэн дүр төрх, шинж чанар болон хувирчээ. Харин компьютерийн харилцаа нь янз бүрийн болоод хувь хүний сонирхол зорилгод үйлчлэгч, нийгэм, агуулгын өргөн сонголт хувилбар бүхий хэрэглэгчдийн орчин байх жишээтэй. Тэгээд ч

компьютерийн харилцаа нь судлаачдын тэмдэглэснээр ямар ч өөр хэрэгслийн орлоогүй, шахан түрээгүй бас шинэ хэв маягийг бий болгоогүй, харин буй тогтолцоо, хэлбэрийг нэмэн баяжуулж, бататгасан гэнэ. Энэ утгаараа түүний ирээдүй нилээд удаан хугацаанд нийгмийн зонхилгогч иргэншлийн харилцаамжийн хэрэгсэл байхын хамт даяарчлал, дэлхийчлэл, эдүгээчлэлийн хүрээнд орших болно.

Компьютерийн хэрэглээ гэр орон, ажлын газар, нийтийн үйлчилгээнд нэвтэрч буй нь мэдээллийн шинэ хэрэгслийн төвшинд үзэх үндэслэл хараахан болж чадахгүй гэнэ. Олон нийтийн харилцаа болохын тулд мэргэжлийн төвшинд компьютерийн сүлжээг ашгийн төлөө агуулга мэдээллийг өргөн хүрээнд, янз бүрийн хүмүүст хүргэх тогтолцооны төвшинд хүрэх ёстой аж. Харин компьютерийн сүлжээгээр хүмүүс өөр хоорондоо мэдээлэл солилцох нь огт өөр үйл ажиллагаа, харьцаа юм. Уламжлалт ойлголтоор ч ийм тогтолцоог олон нийт хэрхэн мэдээллийн хэрэгслийн төвшинд ашиглах, хэрэгсэл эдийн засаг санхүүгийн асуудлаа яаж шийдвэрлэх, тэр бүү хэл ямар үйлчилгээ үзүүлэх нь тодорхойгүй байгаа юм.

Тэгээд ч Интернет шиг харилцааны шинэ технологийн орчныг судлан, дүн шинжилгээ хийхээсээ илүү тодорхойлолт, ойлголтын цогц дэг, эмхэтгэлд оруулах нь чухал болоод буй аж. Түүнчлэн Интернет нь олон нийтийн харилцааны хэрэгслийн шинж чанар

болох "олон нийтийн" ч, "харилцааны хэрэгслийн" ч аль аль ойлголттой дүйх зүйл үгүй, нөхцөл байдал, цаг үеэс шалтгаалан өөр өөрөөр дахин дахин томъёологдсоор ирлээ. Өөрөөр хэлбэл, Интернет нь олон нийтийн харилцааны бусад олон хэрэгслийн цуглуулга бүрдэл гэмээр мэдээллийн орчныг нэгтгэж хүмүүс хоорондын ч, олон нийтийн ч, нэг талын ч, олон талт ч харилцааны бүхий л шинж чанар, хэв маяг оршин буй нь асуудлыг түвэгтэй болгож байгаа юм. Ер нь бол харилцааны аливаа шинэ хэрэгсэл, үзэгдлийг авч үзэхдээ хүмүүс хоорондын юм уу, эсвэл өөр мэдээллийн суваг, хэлбэртэй харьцуулан үздэг жишиг байдаг. Тиймээс ч шинэ мэдээллийн техник технологи нь хүмүүс хоорондын болон олон нийтийн харилцааны орчин бай-

далд уусан, онцлог ялгаа нь замхарч, улмаар нэгэн хэлбэрийн хүрээнд төлөвшин нэвчдэг зүй тогтолтой болно.

Сонирхолтой нь Интернетэд олон нийтийн харилцааны уламжлалт тогтолцооны загвар "эх сурвалж-мэдээлэл-хэрэглэгч" гэсэн томъёоллоор хандах бүрэн боломжтой болоод тэдгээр хүчин зүйлийг нэгтгэсэн энгийн дараалалд ойлгогдож байдаг ч огт өөр шинэ хэв маяг, орчныг бий болгоод байгаа юм.

Интернет нь үндэстэн дамнасан томоохон мэдээллийн компанийн веб хуудсаас, найз нөхөддөө бичсэн электрон шуудангийн зурвас хүртэл янз бүрийн бүхий л хэлбэрийн мэдээллийг багтаасан харилцааны орчин, сүлжээ төдийгүй, олон нийтийн харилцааны уламжлалт мөн чанар, хандлага бүрийг олон талаар өөрөөр үзэхэд хүргээд буй онцлогтой болой. Мэдээллийн эх сур-

валж нь хувь хүн жишээлбэл электрон шуудан, хэсэг бүлгийн асуулт-хариултын харьцаанд байхад мэргэжлийн сэтгүүлч, ажилтнууд сүлжээ болон цахим хэвлэлийн нүүрийг бэлтгэх жишээтэй. Мөн түүнчлэн мэдээллийг хүртэгч, хүлээн авагч нь нэг л хүн байх тохиолдлоос хэдэн сая байж

«
Интернет нь үндэстэн дамнасан томоохон мэдээллийн компанийн веб хуудсаас, найз нөхөддөө бичсэн электрон шуудангийн зурвас хүртэл янз бүрийн бүхий л хэлбэрийн мэдээллийг багтаасан харилцааны орчин, сүлжээ төдийгүй, олон нийтийн харилцааны уламжлалт мөн чанар, хандлага бүрийг олон талаар өөрөөр үзэхэд хүргээд буй онцлогтой болой.

»

болохын дээр, тэд ахар богино эгшинд мэдээлэгчид болон үүрэг, байр сууриа өөрчлөх боломжтой. Ер нь Интернетийн хэрэглэгчдийн асуудал чухал төдийгүй, арилжаа худалдааны зорилгоор мэдээлэл түгээгчдийн хувьд улам бүр ач холбогдолтой болсоор байна. Мэдээж энэ нь харилцааны нөлөө, хэрэглэгчдийн хэрэглээ, хандлагатай холбоотой юм. Интернетийг олон нийтийн харилцааны хувьд судлахад агуулга, мэдээллийн

орчны асуудал илүү холбогддог ба тоо хэмжээ сэдэв утгын хүрээ нь ч өдөр бүр өссөн нэмэгдсээр байгаа билээ. Тийм учраас ч судлаачдын дунд шинэ мэдээллийн хэрэгслийн нөлөө, олон нийтийн санаа бодолд хэрхэн яаж нэвчиж байгаа нь сонирхолтой асуудал нэгэнт болжээ.

Өөр нэгэн асуудал бол мэдээллийн бодит үнэн байдал юм. Уламжлалт хэрэгслийн хувьд бодит үнэн мэдээллийн асуудал тодорхой утгаар аль хэдийн тогтоогдон шийдвэрлэгдсэн, харин Интернет шиг агуу том мэдээллийн сангийн хувьд худал, төөрөгдүүлэлтийн хийгээд үнэн зөв бүхэн бүгд нэгэн "сав"-д агуулагдаж байгаа нь ойлгомжтой юм. Энэ бүхнээс магадгүй бодит үнэн мэдээллийн тухай үзэл баримтлал ч өөрчлөгдөж болох тийм нөхцөл байдалд хүрээд буй нь нууц биш.

Гэвч Интернетийн мэдээллийг тодорхойлох хамгийн зохист хандлага нь нийгмийн харилцааны сүлжээний онол бөгөөд нийгмийн зан үйл болоод хүмүүс хоорондын харилцан холбоог үндэслэн дүгнэлт тайлбараа хийдэг онцлогтой аж. Энэхүү онолоор хүмүүс өөр хоорондоо боломжит бүхий л хэрэгслээр дамжуулан хэдийчинээ идэвхитэй харилцана, төдийчинээ тэдний харилцан холбоо бат зүй зохист байдаг гэнэ. Тиймээс Интернет нь хүмүүсийн нийгэмшлийн харилцан үйлчлэлийн үйл явцыг үргэлжлүүлсний зэрэгцээ нийгмийн уламжлалт зан үйлийг нэмэн өргө-

жүүлжээ. Тиймээс хүмүүс сэтгэл санаа өөдрөг үедээ хувь харилцаанд илүү өдөөгдөж, харин гутранги бол тэрхүү эрэлт хэрэгцээгээ Интернет мэтийн мэдээллийн хэрэгслээр хангадаг болжээ.

Энэхүү дүгнэлт тайлбарыг ч нийгмийн нөлөөллийн онол баталгаажуулж хувь хүний зан үйл, чиг хандлага бүхий нийгмийн нийтлэгшлийн үр дагавартай холбон үздэг байна. Тэдний үзэл судалгаагаар нийгмийн орчин нөлөөгөөр бий болсон хувь хүний зан үйл, хандлага нь уламжлалт бүлгийнхээс илүү болох нь тогтоогджээ.

Эцэст нь мэргэжилтнүүд мэдээллийн шинэ технологийн хөгжлийн хоёр хувилбар байгааг таамаглажээ. Үүний нэг нь хүмүүс дэлгэцээр дамжуулан, гадагшаа гарахгүйгээр худалдаа арилжаа болон бусад ажлаа амжуулах тийнхүү идэвхигүй хүнийшсэн нэгэн болох, нөгөө нь харин ч эргэх холбоот хэрэгсэл нь хувь хүн хоорондын харилцааг идэвхижүүлэх илүү өргөн агуулга, зан үйлийн төвшинд хүргэх тухай юм. Өөрөөр хэлбэл мэдээллийн хэрэгсэл хүний нийгэмч, бодит ахуй орчинг орлох эсэх асуудал эргэх холбоот цахим, электрон, дэлгэцэн харилцааны ирээдүйг тодорхойлж байна гэсэн үг. Үүнд ч энэхүү өгүүллийн утга бас асуулт оршиж байна.

Ишлэл

¹ М а к л ю э н М. 2003. Понимание медиа: внешние расширения человека. М., с. 27.

² З е м л я н о в а Л. 1995. Современная американская коммуникативистика. М., с. 193.

³ 2003. Мэдээлэл холбооны үндсэн сүлжээний өнөөгийн байдал. (Дэд бүтцийн яамны тайлан). УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Б о л д – Э р д э н э Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.

2. З е м л я н о в а Л. 1995. Современная американская коммуникативистика. М.

3. З у л ь к а ф и л ь М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

4. М а к л ю э н М. 2003. Понимание медиа: внешние расширения человека. М.

5. О р т е г а – и – Г а с с е т Х. 1993. Бунтет на масите. София.

6. С и г е л С. 2002. Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг. Софи.

7. Ф р о м м Э. 2002. Эрх чөлөөнөөс дайжихуй. УБ.

8. L e B o n. 1982. The Croud. Harmons-worth.